



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙД**

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: 26 22 27, Факс: (976-51) 26 37 27,
Цахим шуудан: letter@moe.gov.mn,
Цахим хуудас: www.moe.gov.mn

2026.04.15 № 1а/2083
танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн Ерөнхий боловсролын сургуулийн хувьсах зардлын талаар 2026 оны 15 тоот албан бичигтэй танилцаад дараах хариуг хүргүүлж байна.

Ерөнхий боловсролын салбарыг 2027-2029 онд боловсролын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэх бөгөөд стандартчлагдсан суралцахуйгаас хувь хүнд тохирсон, ур чадварт суурилсан суралцахуйг тэргүүлэх чиглэл болгоно. Энэ хүрээнд багшийн мэргэжлийн чадамж, боловсролын дэд бүтэц, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хүртээмжийг сайжруулах замаар хот, хөдөөгийн боловсролын чанар, үр дүнгийн ялгааг бууруулсан тогтолцоо төлөвших нөхцөлийг бүрдүүлнэ. Энэхүү бодлогыг дараах үндсэн зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

(i) чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж, суралцагчдад мэдлэг дамжуулахад бус, амьдралд хэрэглэх чадвар эзэмшүүлэхэд сургалтын үйл ажиллагааг чиглүүлэх;

(ii) боловсролын чанар, үр дүн, тэгш хүртээмжийг сайжруулж, аймаг, сум, нийслэлийн сургуулийн суралцагчдын боловсролын чанарын ялгааг бууруулах;

(iii) багшийн мэргэжлийн ур чадварыг сайжруулах, багшлахуйн бие даасан байдал, мэргэжлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх;

(iv) дижитал болон хиймэл оюунд суурилсан суралцахуйн орчныг бүрдүүлж, суралцагчийн сурах хэв маяг, сонирхол, хөгжлийн онцлог, тусгай хэрэгцээнд нийцсэн сургалтыг дэмжих;

(v) сургалтын байгууллагын удирдлага, зохион байгуулалт, хариуцлагын тогтолцоог сайжруулж, боловсролын үр ашиг, тогтвортой хөгжлийг хангах.

Дээрх зорилтын хүрээнд:

1.Боловсролын хүртээмж, сургалтын дэд бүтэц, орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг хэрэгцээт байршилд оновчтой хийх замаар ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн коэффициент, бүлэг дүүргэлтийг бууруулах;

2.Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, сурах бичгийн шинэчлэлийг эрчимжүүлж, суурь боловсролын сургалтын хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж эхлэх, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсруулах, тохирц нийцлийг шалган сайжруулах;

3.Багш, удирдах ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг бодит хэрэгцээнд нийцүүлэн чанаржуулж, багшийн виртуал туслах ашиглан сургалт зохион байгуулах судлагдахууны тоог нэмэгдүүлэх;

4.Сургалтын байгууллагад суурилсан менежментийг төгөлдөршүүлж, удирдах ажилтныг бэлтгэх, хөгжлийг дэмжих тогтолцоо бүрдүүлэх;

5.Газар зүйн байршил, сургуулийн насны хүн амын тоо, сургалт зохион байгуулахад шаардагдах нөөцөд үндэслэн төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн бүтцийн дахин төлөвлөлт хийж, боловсролын үр ашгийг сайжруулах;

6.Төрөлжсөн сургалттай ахлах сургуулийн тоог нэмэгдүүлж, бие даасан бүтэц, зохион байгуулалтаар хөгжүүлэх;

7.Хичээлийн байрын хүчин чадлын ашиглалтын коэффициент нэгээс бага байгаа сургуулийг бүтэн өдрийн сургалтын тогтолцоо (нэг ээлжээр хичээллүүлэх)-нд бүрэн шилжүүлж, төсвийн үр ашгийг хангах;

8.Технологид суурилсан суралцахуйн шилжилтийг анги танхимд эрчимжүүлж, багшлахуйгаас суралцахуйд шилжих үйл явцыг дэмжих ухаалаг төхөөрөмж, хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлэх;

9.Хувь хүнд тохирсон суралцахуйг дэмжих сургалтын платформ, цахим хичээл, дижитал сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, контентын сан хөгжүүлэлтийг эрчимжүүлж, тэдгээрийг ашиглах тэгш боломж, нээлттэй байдлыг бүрдүүлэх;

10.Ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн сурах үйлийг дэмжихэд дижитал технологи ашиглах, техник, програм хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлж, тэднийг ерөнхий боловсролд бүрэн хамруулах;

11.“Хүүхдэд ээлтэй дотуур байр”, “Эрүүл аюулгүй сургууль”, “Гэрт ойр сургууль” арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

“Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай” Засгийн газрын 2024 оны 39 болон 53 дугаар тогтоолын дагуу ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлаар тооцон санхүүжүүлж байна. Нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг тооцохдоо бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан хүн амын тоо, газар зүйн байршил, сургууль, цэцэрлэгийн ачаалал зэргийг харгалзан суурь болон бусад хувьсах зардал гэсэн ангилалтайгаар олгож байна. Суурь хувьсах зардалд суралцагчийн хичээл сургалтын үйл ажиллагаатай холбоотой зардал болон багшийн цалингийн зардал багтаж байгаа бол бусад хувьсах зардалд сургуулийн хэвийн үйл ажиллагаатай холбоотой захиргааны албан хаагчдын цалингийн зардал, танхимаас гадуурх сургалтын үйл ажиллагаа, хүүхэд хамгаалал, цахим хэрэглээ,

анги танхимын цэвэрлэгээ, багшийн хөгжил, эрүүл мэндийн үйлчилгээний зардлууд багтаж байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын харьяа 19 ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл болон 2022-2026 онд олгосон санхүүжилтийг хавсралтаар гарган хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудастай.



Л.ЭНХ-АМГАЛАН

Боловсролын сайдын 2026 оны 4 дугаар сарын
15-өдрийн тоот албан ёсчигийн нэгдүгээр
хавсралт /20283

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХАРЬАА ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Байгууллагын нэр	2022 он	2023 он	2024 он	2025 он	2026 он
1	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Дархан-Уул аймаг дахь ерөнхий боловсролын ахлах сургууль	62,451.0	75,403.8	134,659.5	158,204.7	150,668.2
2	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа Говь-Алтай аймаг дахь ерөнхий боловсролын ахлах сургууль	160,783.4	226,964.9	292,833.6	373,029.1	613,200.6
3	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль	-	110,700.3	289,383.7	302,025.2	331,768.8
4	Монгол Улсын их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль	-	166,119.6	250,437.1	256,650.9	272,646.0
5	Олон улсын эдийн засаг бизнесийн их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль	-	-	7048.99	7386.72	9662.40
6	ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургууль /коосен/	-	-	39,615.6	88,294.9	106,815.1
7	ХААИС-ийн харьяа Дархан-уул аймаг дахь салбар сургууль	10,269.7	13,230.4	33,786.9	56,124.1	71,220.4
8	Монгол улсын их сургуулийн Дорнод аймаг дахь ерөнхий боловсролын ахлах сургууль	287,554.7	406,045.0	492,192.0	592,009.3	916,313.2
9	Монгол улсын их сургуулийн харьяа Завхан аймаг дахь ерөнхий боловсролын ахлах сургууль	-	-	-	692,700.6	1,504,601.0
10	Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль	-	-	42,174.2	37,363.3	32,395.0
11	Дотоод хэргийн их сургуулийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургууль	467,456.2	405,818.7	792,542.0	871,211.8	1,524,205.8
12	Монгол Улсын Боловсролын их сургуулийн харьяа ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль	-	587,754.0	813,549.7	749,114.6	671,261.0
13	Үндэсний Батлан хамгаалахын их сургуулийн харьяа ерөнхий боловсролын Тэмүүжин өрлөг бүрэн дунд сургууль	1,149,071.2	1,668,960.6	1,687,429.2	1,788,383.6	2,582,714.1
14	Соёл урлагийн их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль	-	123,329.4	276,989.0	267,503.3	264,171.6
15	Үндэсний биеийн тамирын их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль	23,284.2	25,365.9	30,558.1	31,260.2	32,313.6
16	Монгол Улсын их сургуулийн харьяа Хөвд аймаг дахь ерөнхий боловсролын ахлах сургууль	86,352.0	108,094.2	221,406.1	643,708.2	1,027,171.0
17	Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн харьяа Ерөнхий боловсролын Ахлах сургууль	48,178.1	41,458.5	170,032.1	266,499.4	314,109.1
18	ШУТИС-Коосэн Технологийн Коллек	-	-	318,582.1	327,286.1	349,338.0
19	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль	-	189,665.8	377,141.7	355,339.8	330,198.0
	НИЙТ	2,295,400.5	4,148,911.1	6,270,361.8	7,864,095.9	11,104,773.0

Жич: 2020-2021 онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр орон нутгийн төсөвт хуваарилагддаг байсан тул байгууллагаар харах боломжгүй байна.

Боловсролын сайдын 2026 оны 4 дугаар сарын
15-нд өдрийн тоот албан бичгийн нэгдүгээр
хавсралт 10/2026/83



ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХАРЬАА ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

№	Байршил	Байгууллагын нэрс	Хамран сургах тойрогтой эсэх	Ангилал	Төвөөс алслагдсан байдал/км	Суралцагч Бүлэг
1	Дархан-Уул аймаг	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Дархан-Уул аймаг дахь ерөнхий боловсролын ахлах сургууль	Үгүй	Ахлах сургууль /10-12-р ангитай/	0	150
2	Говь-Алтай аймаг	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа Говь-Алтай аймаг дахь ерөнхий боловсролын ахлах сургууль	Үгүй	Ахлах сургууль /10-12-р ангитай/	0	51
3	Нийслэл-Сүхбаатар дүүрэг	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль	Үгүй	Ахлах сургууль /10-12-р ангитай/	1	380
4	Нийслэл-Сүхбаатар дүүрэг	Монгол Улсын их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль	Үгүй	Ахлах сургууль /10-12-р ангитай/	2	374
5	Нийслэл-Баянгол дүүрэг	Олон улсын эдийн засаг бизнесийн их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль	Үгүй	Ахлах сургууль /10-12-р ангитай/	5	10
6	Өмнөговь аймаг	ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургууль	Үгүй	Ахлах сургууль /10-12-р ангитай/	600	108
7	Дархан-Уул аймаг	ХААИС-ийн харьяа Дархан-уул аймаг дахь салбар сургууль	Үгүй	Ахлах сургууль /10-12-р ангитай/	0	72
8	Дорнод аймаг	Монгол улсын их сургуулийн Дорнод аймаг дахь ерөнхий боловсролын ахлах сургууль	Үгүй	Ахлах сургууль /10-12-р ангитай/	1	112
9	Завхан аймаг	Монгол улсын их сургуулийн харьяа Завхан аймаг дахь ерөнхий боловсролын ахлах сургууль	Үгүй	Ахлах сургууль /10-12-р ангитай/	3	178
10	Нийслэл-Хан-Уул дүүрэг	Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль	Үгүй	Ахлах сургууль /10-12-р ангитай/	6	39
11	Нийслэл-Баянзүрх дүүрэг	Дотоод хэргийн их сургуулийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургууль	Үгүй	Ахлах сургууль /10-12-р ангитай/	9	309
12	Нийслэл-Сүхбаатар дүүрэг	Монгол Улсын Боловсролын их сургуулийн харьяа ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль	Үгүй	Бүрэн дунд сургууль /1-12-р ангитай/	0	1091
13	Нийслэл-Баянзүрх дүүрэг	Үндэсний Батлан хамгаалахын их сургуулийн харьяа ерөнхий боловсролын Тэмүүжин өрлөг бүрэн дунд сургууль	Үгүй	Ахлах сургууль /10-12-р ангитай/	8	506
14	Нийслэл-Цингэлтэй дүүрэг	Соёл урлагийн их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль	Үгүй	Ахлах сургууль /10-12-р ангитай/	1	292
15	Нийслэл-Хан-Уул дүүрэг	Үндэсний биений тамирын их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль	Үгүй	Ахлах сургууль /10-12-р ангитай/	15	38
16	Ховд аймаг	Монгол Улсын их сургуулийн харьяа Ховд аймаг дахь ерөнхий боловсролын ахлах сургууль	Үгүй	Ахлах сургууль /10-12-р ангитай/	0	129
17	Орхон аймаг	Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн харьяа Ерөнхий боловсролын Ахлах сургууль	Үгүй	Ахлах сургууль /10-12-р ангитай/	0	306
18	Нийслэл-Сүхбаатар дүүрэг	ШУТИС-Коосэн Технологийн Коллеж	Үгүй	Бүрэн дунд сургууль /1-12-р ангитай/	1	391
19	Нийслэл-Сүхбаатар дүүрэг	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль	Үгүй	Ахлах сургууль /10-12-р ангитай/	1	458

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛАГТЫН ХАРЬАА ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

Бүлэг дүүргэлт	Нийт ажилтан	Үндсэн ажилтан	Нийт багш	Үндсэн багш	Хичээлийн байр	Бусдын эзэмшлийн хичээлийн байр	Хичээлийн байрны хүчин чадал	Эзлэлийн коэффициент	Мэргэжлийн хяналтын дүгнэлт гарсан хичээлийн байр	Дотуур байр	Бусдын эзэмшлийн дотуур байр	Дотуур байрны хүчин чадал	Мэргэжлийн хяналтын дүгнэлт гарсан Дотуур байр	Биеийн тамирын заалтай эсэх	Интернетэд холбогдсон эсэх
25.0	15	11	12	8	1	0	150	1	0	0	0	0	0	Үгүй	Тийм
17.0	14	9	7	5	1	1	110	0.5	0	0	0	0	0	Үгүй	Үгүй
25.3	45	25	39	18	1	1	600	0.6	0	0	0	0	0	Тийм	Тийм
24.9	33	30	23	20	1	0	360	1	0	0	0	0	0	Үгүй	Тийм
5.0	15	11	10	4	1	0	100	0.1	0	0	0	0	0	Тийм	Тийм
18.0	26	20	14	12	1	1	300	0.4	0	0	0	0	0	Үгүй	Тийм
18.0	14	13	9	9	1	0	150	0.5	0	0	0	0	0	Тийм	Тийм
18.7	22	18	14	10	1	0	60	1.9	0	0	0	0	0	Үгүй	Тийм
22.3	26	26	14	11	1	0	960	0.2	0	1	0	200	0	Тийм	Тийм
13.0	19	14	12	2	1	0	120	0.3	0	0	0	0	0	Үгүй	Тийм
34.3	35	31	21	17	1	1	270	1.1	0	0	0	0	0	Тийм	Тийм
31.2	83	83	68	68	1	1	1030	1.1	0	0	0	0	0	Тийм	Үгүй
33.7	67	66	13	13	1	0	350	1.4	0	0	0	0	0	Тийм	Тийм
32.4	63	21	49	12	1	0	550	0.5	0	0	0	0	0	Үгүй	Тийм
12.7	19	15	14	9	1	1	240	0.2	0	0	0	0	0	Тийм	Тийм
21.5	19	19	12	9	1	0	150	0.9	0	0	0	0	0	Үгүй	Тийм
21.9	39	30	32	27	1	0	200	1.5	0	0	0	0	0	Тийм	Тийм
27.9	29	27	18	14	1	0	310	1.3	0	0	0	0	0	Үгүй	Тийм
32.7	26	25	19	18	1	0	450	1	0	0	0	0	0	Үгүй	Үгүй